**Захиалагч:** Хэнтий аймгийн ЗДТГазар

**Гүйцэтгэгч:** "Гео Зураглал" ХХК

<b>Зургийн бүрдэл:</b>	Ажлын зураг	5- дэвтэр
	Техникийн шаардлага	5- дэвтэр
	Тайлбар бичиг	5- хавтас
	Инженер – геологийн судалгааны ажлын дүгнэлт	1 дэвтэр
	Хэмжилт зураглалын тайлан	1 дэвтэр

Төсөллөж байгаа замуудын инженер геологийн судалгааг "Ганхошуу" ХХК, хэмжилт, зураглалыг "Гео Меп" ХХК тус тус гүйцэтгэжээ. Авто зам барихаар төлөвлөсөн зурвас талбайд 1987 онд өрөмдсөн 11 цооногоос, сайрхаг хөрс, шавранцар хөрс илэрчээ. Эдгээр хөрсийг 0.3м зузаан элсэнцэр чигжээстэй хайрга, хайрган хөрс бүхий авто замын далан болон ургамлын үндэс бүхий өнгөн хөрс элсэнцэр хучиж тогтжээ. Шавранцар хөрс нь хүчтэй овойлттой хөрсөнд нормчлогдоно. Хөрсний ус №12 цооногт 1.8 м, №25 цооногт 2.5м, №26 цооногт 3.5м гүнээс илэрсэн. Бусад цооногт хөрсний ус илрээгүй.

№1-р зам нь дотроо 2 хэсэгтэй, зорчих хэсгийн өргөн 1-р хэсэгт 6 метр, 2-р хэсэгт 7 метр өргөн, нийт урт 387 метр эхний 50 метр замын зүүн гар талаар, түүнээс цааш замын 2 талаар тус бүр 1.5 м өргөн явган зам, 1 м өргөн ногоон байгууламжийн зурвасыг замын зүүн гар талд төлөвлөсөн. 1-р хэсгийн Пк 0+00 – Пк 0+80-ын хооронд чулуун зам, бусад хэсэгт болон 2-р хэсэгт асфальтбетон зорчих хэсэгтэй байхаар төлөвлөсөн.

#### Чулуун зорчих хэсгийн бүтээц :

Суурийн доод үе - 25см

Буталсан чулуун суурь - 20см

Чулуун хучлага /10x10/ - 10см

#### Асфальтбетон зорчих хэсгийн бүтээц :

Суурийн доод үе - 30см

Цементээр бэхжүүлсэн суурь - 20см

Том ширхэгтэй асфальтбетон - 4см

Жижиг ширхэгтэй асфальтбетон - 3см

Төлөвлөж байгаа замын доогуур хөндлөн гарч байгаа бохирын шугамууд дээр даацын бетон хавтан, дулааны шугамууд дээр тагийг хамгаалсан даацын хавтан тавьж хучитгэхээр төлөвлөжээ. Зорчих хэсгийн усыг 2 тал руу, хөвөөн доогуур U хэлбэрийн бетон цорго тавьж гаргахаар төвөлөжээ. Гудам руу гарах 17ш гарц гаргажээ.



**№2-р зам** нь 488 метр урт, зорчих хэсгийг нутаг дэвсгэрийн туслах гудамж, замын ангиллаар 6 метр өргөн төлөвлөсөн, түүний 2 талаар тус бүр 1.5 метр өргөн явган замтай. Замын Пк 0+00 – Пк 1+65-ын хооронд чулуун зам, Пк 1+65 – Пк 4+88-ын хооронд асфальтбетон хучлагатай байхаар төлөвлөжээ.

Төлөвлөж байгаа замын доогуур хөндлөн гарч байгаа цэвэр, бохир усны шугам, дулааны шугамуудыг бетон хавтангаар хамгаалахаар тусгажээ. Хамгаалалтын төмөр хайс 21 у/м тавихаар төлөвлөжээ.

**№3-р зам** нь 632.9 метр урт, зорчих хэсгийг нутаг дэвсгэрийн гол гудамж, замын ангиллаар 7 метр өргөн төлөвлөжээ. Түүний 2 талаар тус бүр 1.5 метр өргөн явган зам, Пк 2+80-аас цааш замын зорчих хэсгийн 2 талаар 1.5 метр өргөн ногоон байгууламжийн зурвастай байхаар тусгажээ.

Асфальтбетон замын зорчих хэсгийн бүтээц нь 1-р замтай ижил. Замын зорчих хэсгийн ус нүхтэй хашлагаар гарч, 0.3м х 0.3м хэмжээтэй дөрвөлжин цоргоор гадагш зайлуулагдахаар төлөвлөгджээ.

**№4-р зам** нь 2 хэсэгтэй бөгөөд 1-р хэсгийн урт 832м, 2-р хэсгийн урт 551.8м, нийт урт 1383.8 метр. Замын зорчих хэсгийг нутаг дэвсгэрийн гол гудамж, замын ангиллаар 7 метр өргөн, түүний 2 талаар тус бүр 1.5 метр өргөн явган зам, тус бүр 1.5 метр ногоон байгууламжийн зурвас төлөвлөжээ. Харин 1-р хэсгийн замын баруун гар талаар 2 метр өргөн дугуйн зам төлөвлөжээ.

Зорчих хэсгийн болон явган хүний замын хучилтын бүтээц, 1-р замынхтай ижил. Харин дугуйн замыг 5см зузаан асфальтбетон хучлагатай төлөвлөжээ. 1 ба 2-р хэсгийн замын дагууд автобусны зогсоол, гарцуудыг гаргасан. 1-р хэсэгт 289 метр, 2-р хэсэгт 64 метр хамгаалалтын хайс тавихаар төлөвлөжээ.

Зорчих хэсгийн усыг хөвөөн доогуур гадагш зайлуулах 0.3 х 0.3-ын хэмжээтэй бетон сувгийг 131.5 у/м уртад тавихаар төлөвлөжээ.

**№5-р зам** нь 1060 метр урт үргэлжлэх бөгөөд замын зорчих хэсгийг нутаг дэвсгэрийн гол гудамж, замын ангиллаар 7 метр өргөн түүний 2 талаар тус бүр 1.5 метр өргөнтэй явган хүний зам, мөн 1.5 метр ногоон байгууламжийн зурвас, замын баруун гар талаар 2 метр өргөнтэй унадаг дугуйн зам төлөвлөжээ.

Зорчих хэсгийн болон явган хүний замын хучилтын бүтээц нь 1-р замынхтай адил. Харин дугуйн зам нь элс-хайрган хольц дээр 5см зузаан асфальтбетон хучлагатай төлөвлөжээ. 1 ба 2-р хэсгийн замын дагууд автобусны зогсоол, гарцуудыг гаргасан. Шаардлагатай газруудад 23ш гарц, автобусны 4 зогсоол төлөвлөсөн. Хамгаалалтын хайс хэсэгт 195 метр тавихаар тусгажээ.

Зорчих хэсгийн усыг хөвөөн доогуур гадагш зайлуулах 0.3 х 0.3-ын хэмжээтэй бетон сувгийг 28 у/м тавихаар төлөвлөжээ. Цэвэр бохирын шугам болон дулааны шугам авто зам хөндлөн гарч байгаа газруудад даацын бетон хавтан тавихаар төлөвлөжээ.

#### **Экспертийн дүгнэлт :**

Хэнтий аймгийн төв Чингис хотод барих 5 замын зураг төсөл нь Хот, суурины гудамж, зам төлөвлөх БНБД 32-01-04 ийн шаардлагыг хангасан байна.

Эксперт №11-01,

Монгол Улсын Зөвлөх инженер,  И.Гончигзэвэг

**Монгол Улс**  
**И.Гончигзэвэг**  
**инженер**  
**037-95**

Зураг төслийн баримт бичгийн  
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР: Инженер-геологийн дүгнэлт

Д/Д	Утга	Тайлбар
1.	Объектийн байршил, хүчин чадал	Хятагсай аймгад, Увс сум, Хятагсай сумын захиргааны хязгаар дотор 4.0 км овоо дамжуулах трасс
2.	Объектийн нэр, шифр	Увс сум, Хятагсай сум, 4.0 км овоо дамжуулах трасс
3.	Хайгуул, судалгааны ажил гүйцэтгэх даалгавар	Засварласан
4.	Судалгааны ажил гүйцэтгэх дэвсгэр зураг	Зөвхөн зурагтай. 1:1000
5.	Байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд	Төв, 90% зураг Увс сум, 4.0 км овоо дамжуулах трасс
6.	Объектын бүрдлийн хэсгийн нэр, хуудасны тоо, гүйцэтгэсэн ААН байгууллага	Төв, "Төв" ХХК. Хятагсай - 15, Хятагсай - 27.
7.	Тооцоо, тооцооны программ, тооцсон байгууллагын нэр, гүйцэтгэсэн инженер	Төв, "Төв" ХХК. Боловруулсан инженер А. Хятагсай, Д. Хятагсай
8.	Төлөвлөлт, техникийн шийдэл	Төв, Хятагсай
9.	Буурь хөрсний инженер-геологийн дүгнэлтийн архив №, боловруулсан инженер, хөрсний ерөнхий дүгнэлт, хөрсний усны түвшин, улирлын хөлдөлтийн гүн, газар хөлдөлтийн балл	Архив № 07-2016-015 Засварласан зурагтай 4.0 км Засварласан зурагтай 4.0 км
Дүгнэлтийн товч утга		
1.	Инженер-геологийн шийдэл нь дагаж мөрдөж буй норм, дүрэм, стандартын дагуу зохиогдсон эсэх	Норм, стандартын дагуу хийгдсэн
2.	- Засварласан ажил Засварласан ажил	Зассан тухай тэмдэглэл, тайлбар
3.	Дүгнэлт бичсэн: Эхтэй № 11-03 Огноо: 2016 Овог нэр: С. Должин 98-118	Засварласан. (Тайлбар хийсэн) ХХК-ийн инженер (Овог нэр).....гарын үсэг..... Огноо.....




Зураг төслийн баримт бичгийн

**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1**

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР:

**ТӨСӨВ** - 5 дэвтэр, 109 хуудас

Д/Д	Утга	Тайлбар
1	Объектийн байршил, хүчин чадал	Хэнтий аймаг, Хэрлэн сум, Чингис хотын төвийн шинээр баригдах авто замын ажил
2	Объектийн нэр, шифр	Хэнтий аймаг, Хэрлэн сум, Чингис хотын төвийн шинээр баригдах авто замын ажил
3	Объектын бүрдлийн хэсгийн нэр, хуудасны тоо, гүйцэтгэсэн ААН байгууллага	Төсвийн тооцоо 5 дэвтэр, нийт 109 хуудас, Гео Зураглал ХХК
4	Төсвийн тооцооны праграмм, төсвийн тооцоог хийсэн байгууллагын нэр, гүйцэтгэсэн инженер	Мэргэшсэн төсөвчин С. Бат-Амгалан
5	Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын тоо хэмжээг үнэн зөв тодорхойлсон байдал	Тоо хэмжээг Гео Зураглал ХХК -ийн зургийн инженер Н. Нямсүрэн шалгаж баталгаажуулсан болно.
6	Төсвийн тооцоонд ашигласан норм, норматив, үнэ үнэлгээ	ЗТАЖуулчлалын Сайдын 2007 оны 11 сарын 20-ны өдрийн 186 тоот тушаалаар батлагдсан "Авто замын барилгын төсвийн жишиг норм" БНБД 81-25-07, Авто зам, замын байгууламжийн засварын ажлын төсвийн жишиг норм" БНБД 81-26-07, "Төмөрбетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм" БНБД 81-28-07-оор үнэлсэн байна.
7	Төсвийн тооцооны арга, аргачлалын оновчтой байдал, төслөөр тодорхойлсон нөөцийг оновчтой ашигласан байдал	Тийм
8	Төсвийн тооцоо, түүний хэлбэржүүлэлтэд зайлшгүй оруулах шаардлагатай завсар, өөрчлөлт	<ol style="list-style-type: none"> <li>Зарим материалын үнийг дахин хянах,үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Далангийн материал</li> <li>Суурийн доод үеийн материал</li> <li>Элс-цементийн зуурмаг</li> </ul> </li> <li>Зарим материалын тээврийн зэргийг 1 болгож засах,үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Балк</li> <li>Бетон хольцнууд</li> <li>Явган замын хавтан</li> <li>Чулуу</li> <li>Зай баригч хуванцар хоолой</li> <li>Буталсан чулуун суурийн хрльц</li> <li>скоч</li> </ul> </li> </ol>

<i>Дүгнэлтийн товч утга</i>	
1.	<p>Төвийн тооцоо нь дагаж мөрдөж буй норм, дүрэм, стандартын дагуу, оновчтой зохиогдсон эсэх</p> <p>Төсвийн тооцоог ЗТАЖуулчлалын Сайдын 2007 оны 11 сарын 20-ны өдрийн 186 тоот тушаалаар батлагдсан "Авто замын барилгын төсвийн жишиг норм" БНБД 81-25-07, "Төмөрбетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм" БНБД 81-28-07, Авто зам, замын байгууламжийн засварын ажлын төсвийн жишиг норм" БНБД 81-26-07-оор үнэлсэн байна. "Авто зам, замын байгууламжийн барилга засвар арчлалтын ажлын төсөв зохиох заавар"-ын дагуу төсвийг зохиосон байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хэнтий аймаг, Хэрлэн сум, 3-р багийн хороолол доторх 0.387км замын барилгын ажлын төсөвт өртгийг 438 189 389 төгрөгөөр;</li> <li>2. Хэнтий аймаг, Хэрлэн сум, Цэцэн Хан худалдааны төвийн зүүн талын уулзвараас Цахилгаан түгээх сүлжээний баруун талын уулзвар хүртэлх 0.488км замын барилгын ажлын төсөвт өртгийг 519 025 281 төгрөгөөр;</li> <li>3. Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг, их тойруугийн замаас хойш шүүхийн шийдвэр гүйцэтгэх албана хашааны зүүн хойд уулзвар хүртэлх 0.632км замын барилгын ажлын төсөвт өртгийг 621 115 965 төгрөгөөр;</li> <li>4. Хэнтий аймаг, Хэрлэн сум, 5-р баг, сариг хорооллын баруун урд уулзвараас шинэ Өндөр хаан чиглэлийн 1.383км замын барилгын ажлын төсөвт өртгийг 1 435 525 167 төгрөгөөр;</li> <li>5. Хэнтий аймаг, Хэрлэн сум, 5-р баг, Соёлын төвийн хойд уулзвараассариг хороолол болон дулаан хороолол дундуур хойш үргэлжлэх 1.060км замын барилгын ажлын төсөвт өртгийг 1 103 223 367 төгрөгөөр тус тус хянаж баталгаажуулав.</li> </ol>
<p>Дүгнэлт бичсэн:</p> <p>Эксперт эксперт № 12-04</p> <div style="text-align: center;">  <p>МОНГОЛ УЛС ЗТТ-03-15 Аюурзаны СЭЛЭНГЭ СЭЛЭНГЭ ТЭРГҮҮЛЭХ ТӨСӨВЧИН 2015-2020</p> </div> <p style="text-align: right;">/ А. СЭЛЭНГЭ/</p> <p style="text-align: center;">2016 оны 8-р сарын 29-ны өдөр</p>	

Эксперт дүгнэлтийг компьютерээр 2 хувь бичиж, гарын үсэг, тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.

**Зураг төслийн баримт бичгийн  
ЭКСПЕРТИЗИЙН ДҮГНЭЛТИЙН ХАРИУ, ХАВСРАЛТ №2**

**ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР:**  
Төсөв - 5 дэвтэр, 109 хуудас

2016 оны 8 сарын 29 өдөр

Д/Д	Утга	Тайлбар
1	Объектийн байршил, хүчин чадал	Хэнтий аймаг, Хэрлэн сум, Чингис хотын төвийн шинээр баригдах авто замын ажил
2	Объектийн нэр, шифр	Хэнтий аймаг, Хэрлэн сум, Чингис хотын төвийн шинээр баригдах авто замын ажил
3	Объектын бүрдлийн хэсгийн нэр, хуудасны тоо, гүйцэтгэсэн ААН байгууллага	Төсвийн тооцоо 5 дэвтэр, нийт 109 хуудас, Гео Зураглал ХХК

д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга
1	Зарим материалын үнийг дахин хянах, үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Далангийн материал</li> <li>• Суурийн доод үеийн материал</li> <li>• Элс-цементийн зуурмаг</li> </ul>	Хэнтий аймгийн Иргэдийн хурлын тогтоолыг хавсаргалаа
2	Зарим материалын тээврийн зэргийг 1 болгож засах, үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Балк</li> <li>• Бетон хольцнууд</li> <li>• Явган замын хавтан</li> <li>• Чулуу</li> <li>• Зай баригч хуванцар хоолой</li> <li>• Буталсан чулуун суурийн хрльц</li> <li>• скоч</li> </ul>	Материалуудын тээврийн зэргийг заслаа

*Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан:*


*Тэргүүлэх төсөвчин, эксперт № 12-04*



**А. СЭЛЭНГЭ**

2016 оны 8-р сарын 30-ны өдөр

*Биелэлтийн тайлбар бичсэн: мэргэшсэн төсөвчин С. Бат-Амгалан*



**С. БАТ-АМГАЛАН**

2016 оны 8-р сарын 30-ны өдөр

*Эксперт дүгнэлтийг компьютерээр 2 хувь бичиж, гарын үсэг, тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.*

Зураг төслийн баримт бичгийн  
**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1**


ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО

Хэнтий аймаг, Хэрлэн сумын нутаг дэвсгэрт

1. Хэрлэн сумын 3-р баг: Хөдөлмөрийн хэлтсийн баруун хойд талын уулзвараас давхар дэлгүүрийн баруун хойд тал хүртэл, "Соёолж" худалдааны төвийн зүүн хойд талаас "Мөнх шувуут" ХХК-ийн зүүн урд талын уулзвар хүртэл 0,396 км авто замын трасст орсон холбооны худаг сувагчлал хамгаалах. ГХ-~~6~~ хуудас
2. Хэрлэн сумын 4-р баг: Их тойруугийн замаас хойш ШШГА-ны хашааны зүүн хойд уулзвар хүртэлх 0,632 км авто замын трасст орсон холбооны худаг сувагчлал хамгаалах. ГХ-~~11~~ хуудас
3. Хэрлэн сумын 4-р баг: ЦТС салбарын баруун талын уулзвараас "Цэуэн хан" худалдааны төвийн уулзвар хүртэл 0,489 км авто замын трасст орсон холбооны худаг сувагчлал хамгаалах. ГХ-~~16~~ хуудас
4. Хэрлэн сумын 5-р баг: Соёлын төвийн хойд талын уулзвараас хойш Сариг болон Дулаан хорооллын дундуун хойш үргэлжлэх 1,060 км авто замын трасст орсон холбооны худаг сувагчлал хамгаалах. ГХ-~~17~~ хуудас
5. Хэрлэн сумын 5-р баг: Сариг хорооллын баруун урд талын уулзвараас хойшоо Өндөрхаан чиглэлийн 1,384 км авто замын трасст орсон холбооны худаг сувагчлал хамгаалах. ГХ-~~14~~ хуудас

2016 оны 9 дугаар сар 05

Д/Д	Утга	Тайлбар
1	Объектын нэр	Холбооны шугамын шилжүүлгийн ажлын зураг, төсөв
2	Объектын байршил, хүчин чадал	Хэнтий аймаг, Хэрлэн сумын нутаг дэвсгэрт 3, 4, 5-р баг
3	Зураг төслийн байгууллага	ЕГ: "Гео зураглал" ХХК, ТГ: "Арбэл-Алтай" ХХК
<b>3. Дүгнэлтийн товч утга:</b> /Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7-р зүйлээс/		
4	7.5.1. барилга байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зураг, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	"МХС" ТӨХК-ийн Хэнтий аймгийн Холбооны газрын 16/14 тоот техникийн нөхцөлтэй, "МХС" ТӨК-ийн Хэнтий аймгийн Холбооны газар, Хэнтий аймгийн Цагдаагийн газартай тус тус зөвшилцсөн байна.
5	7.5.2. барилга, байгууламжийн архитектур төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	Холбооны сувагчлалыг хамгаалах хэсэгт дараах төлөвлөлтүүдийг хийсэн байна. Үүнд: - Одоо байгаа сувагчлалд зарим хэсэгт нэмж сувагчлал суурилуулан багтаамжийг нэмэгдүүлсэн байна. - Газар шорооны ажлын үед одоо байгаа сувагчлалыг зам хөндлөн хэсэгт хамгаалалтын ган хоолой хийхээр - Газар шорооны ажлын үед одоо байгаа сувагчлалыг зам хөндлөн хэсэгт хамгаалалтын бетон блок хийхээр - Газар шорооны ажлын үед одоо байгаа сувагчлалыг зам хөндлөн хэсэгт хамгаалалтын бетон блок хийхээр - Шинээр сувагчлал хийхээр /худаг хоорондын зайг 120 м-ээс хэтрүүлэхгүй/

		тус тус төлөвлөлтийг сонгож хийсэн байна.
6	7.5.3. барилга байгууламжийн байршил, хот төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон байршил, талбайн инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаархи дүгнэлт;	
7	7.5.4. зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байдал;	Төлөвлөж буй авто зам доогуур холбооны сувагчлалыг хамгаалалттай төмөр яндан дотуур сүвлэж, эсвэл төмөр бетон лоткигоор хамгаалж гаргахаар тооцсон байна.
8	7.5.5. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	
9	7.5.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	
10	7.5.7. хөрсний бохирдлоос хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үйлдвэрийн бохирдсон усыг цэвэрлэж ашиглах боломж, гадагш хаяж байгаа бохирдсон агаар, ус норматив үзүүлэлтийг хангаж буй эсэх;	
11	7.5.8. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл;	Агаарын баганаар татсан болон одоо байгаа газрын кабелийг холбооны сувагчлалд оруулж өгсөнөөр цаашид зам засварын ажил хийгдэхэд холбооны сувагчлал ямар ч нөлөө үзүүлэхгүй болсоны дээр холбооны шугам өргөтгөх шаардлагагүй ач холбогдолтой болсон гэж үзэж байна.
12	7.5.9 барилга байгууламжийн гаднахь ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	
13	7.5.10. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	
14	7.6. Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	Холбогдох норм дүрмийн шаардлага хангасан тул дээрх зураг төслөөр угсралтын ажлыг хийх боломжтой гэж үзлээ
Дүгнэлт бичсэн: Эксперт № <u>71-04</u> Дархжавын БАЛМАА /овог, нэр/ 201 <u>6</u> . оны <u>09</u> сарын <u>02</u> -ны өдөр		

Зураг төслийн баримт бичгийн  
**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1**

ЗУРАГ ТӨСВИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО 95 хуудас

Хэнтий аймаг, Хэрлэн сумын нутаг дэвсгэрт

1. Хэрлэн сумын 3-р баг: Хөдөлмөрийн хэлтсийн баруун хойд талын уулзвараас давхар дэлгүүрийн баруун хойд тал хүртэл, "Соёолж" худалдааны төвийн зүүн хойд талаас "Мөнх шувуут" ХХК-ийн зүүн урд талын уулзвар хүртэл 0,396 км авто замын трасст орсон холбооны худаг сувагчлал хамгаалах. Төсөв 12 хуудас
2. Хэрлэн сумын 4-р баг: Их тойруугийн замаас хойш ШШГА-ны хашааны зүүн хойд уулзвар хүртэлх 0,632 км авто замын трасст орсон холбооны худаг сувагчлал хамгаалах. Төсөв 23 хуудас
3. Хэрлэн сумын 4-р баг: ЦТС салбарын баруун талын уулзвараас "Цэуэн хан" худалдааны төвийн уулзвар хүртэл 0,489 км авто замын трасст орсон холбооны худаг сувагчлал хамгаалах. Төсөв 16 хуудас
4. Хэрлэн сумын 5-р баг: Соёлын төвийн хойд талын уулзвараас хойш Сариг болон Дулаан хорооллын дундуун хойш үргэлжлэх 1,060 км авто замын трасст орсон холбооны худаг сувагчлал хамгаалах. Төсөв 21 хуудас
5. Хэрлэн сумын 5-р баг: Сариг хорооллын баруун урд талын уулзвараас хойшоо Өндөрхаан чиглэлийн 1,384 км авто замын трасст орсон холбооны худаг сувагчлал хамгаалах. Төсөв 23 хуудас

2016 оны 9 дугаар сар 06

Д/Д	Утга	Тайлбар
1	Объектын нэр	Холбооны шугамын шилжүүлгийн ажлын зураг, төсөв
2	Объектын байршил, хүчин чадал	Хэнтий аймаг, Хэрлэн сумын нутаг дэвсгэрт 3, 4, 5-р баг
3	Зураг төслийн байгууллага	ЕГ: "Гео зураглал" ХХК, ТГ: "Арбэл-Алтай" ХХК
<b>3. Дүгнэлтийн товч утга:</b> /Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7-р зүйлээс/		
4	7.5.1. барилга байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зураг, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	"МХС" ТӨХК-ийн Хэнтий аймгийн Холбооны газрын 16/14 тоот техникийн нөхцөлтэй, "МХС" ТӨК-ийн Хэнтий аймгийн Холбооны газар, Хэнтий аймгийн Цагдаагийн газартай тус тус зөвшилцсөн байна.
5	7.5.2. барилга, байгууламжийн архитектур төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	Холбооны сувагчлалыг хамгаалах хэсэгт дараах төлөвлөлтүүдийг хийсэн байна. Үүнд: - Одоо байгаа сувагчлалд зарим хэсэгт нэмж сувагчлал суурилуулан багтаамжийг нэмэгдүүлсэн байна. - Газар шорооны ажлын үед одоо байгаа сувагчлалыг зам хөндлөн хэсэгт хамгаалалтын ган хоолой хийхээр - Газар шорооны ажлын үед одоо байгаа сувагчлалыг зам хөндлөн хэсэгт хамгаалалтын бетон блок хийхээр - Газар шорооны ажлын үед одоо байгаа сувагчлалыг зам хөндлөн хэсэгт хамгаалалтын бетон блок хийхээр



		- Шинээр сувагчлал хийхээр /худаг хоорондын зайг 120 м-ээс хэтрүүлэхгүй/ тус тус төлөвлөлтийг сонгож хийсэн байна.
6	7.5.3. барилга байгууламжийн байршил, хот төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон байршил, талбайн инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаархи дүгнэлт;	
7	7.5.4. зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байдал;	Төлөвлөж буй авто зам доогуур холбооны сувагчлалыг хамгаалалттай төмөр яндан дотуур сүвлэж, эсвэл төмөр бетон лоткигоор хамгаалж гаргахаар тооцсон байна.
8	7.5.5. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	
9	7.5.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	
10	7.5.7. хөрсний бохирдлоос хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үйлдвэрийн бохирдсон усыг цэвэрлэж ашиглах боломж, гадагш хаяж байгаа бохирдсон агаар, ус норматив үзүүлэлтийг хангаж буй эсэх;	
11	7.5.8. инженерийн шугам сүлжээний уртын дагуухь төлөвлөлтийн оновчтой шийдэл;	Агаарын баганаар татсан болон одоо байгаа газрын кабелийг холбооны сувагчлалд оруулж өгсөнөөр цаашид зам засварын ажил хийгдэхэд холбооны сувагчлал ямар ч нөлөө үзүүлэхгүй болсоны дээр холбооны шугам өргөтгөх шаардлагагүй ач холбогдолтой болсон гэж үзэж байна.
12	7.5.9. барилга байгууламжийн гаднахь ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	
13	7.5.10. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	
14	7.6. Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	Холбогдох норм дүрмийн шаардлага хангасан тул дээрх зураг төслөөр угсралтын ажлыг хийх боломжтой гэж үзлээ
<p>Дүгнэлт бичсэн:</p> <p>Эксперт № 04/05 Цагаач Баярбилэг /овог, нэр /</p> <p>2016 оны 09 сарын 06 -ны өдөр</p>		



**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ**

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР. № 111/2016

Цахилгааны хэсэг.....

2016 оны 09 сарын 16 өдөр

Д	Утга	Тайлбар
1	Объектын байршил,	Хэнтий аймаг Чингис хаан хот Хэрлэн сум
2	Объектын нэр, Объектын шифр	<ul style="list-style-type: none"> <li>- Хэнтий аймаг Чингис хаан хотын автозамын шинэчлэлтийн ажил</li> <li>- Хэрлэн сумын 3-р багийн орон сууцны хороолол доторх 0.386км автозамын трасст орсон ЦШС-г шилжүүлэх ажил /автозам №1-1/ ГЦ.1-ГЦ.13 , /автозам №1-1/ 0.386км автозамын гадна гэрэлтүүлэг ГГ.1-ГГ.15 шифр БЭ-2016-043</li> <li>- Хэрлэн сум 4-р баг Их тойруугийн замаас хойших Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны хашааны зүүн хойд уулзвар хүртлэх 0.632км автозамын трасст орсон ЦШС-г шилжүүлэх ажил /автозам №3-1/ ГЦ.1-ГЦ.13 /автозам №3-1/ 0.632км автозамын гадна гэрэлтүүлэг ГГ.1-ГГ.15 шифр БЭ-2016/045</li> <li>- Цэцэн хан худалдааны төвийн зүүн талын уулзвараас Цахилгаан түгээх сүлжээний баруун талын уулзвар хүртлэх 0.489км автозамын трасст орсон ЦШС-г шилжүүлэх ажил /автозам №2-1/ ГЦ.1-ГЦ.13 /автозам №2-1/ 0.489км автозамын гадна гэрэлтүүлэг ГГ.1-ГГ.15 шифр БЭ-2016/044</li> <li>- Хэрлэн сум 5-р баг Сариг хорооллын баруун урд уулзвараас Шинэ Өндөр хаан чиглэлийн 1.383км автозамын трасст орсон ЦШС-г шилжүүлэх ажил /автозам №4-1/ ГЦ.1-ГЦ.13 /автозам №4-1/ 1.383км автозамын гадна гэрэлтүүлэг ГГ.1-ГГ.18 шифр БЭ-2016/046</li> <li>- Хэрлэн сум 5-р баг Соёлын төвийн хойд талын уулзвараас Сариг хороолол болон Дулаан хорооллын дундуур хойш үргэлжлэх 1.060км автозамын трасст орсон ЦШС-г шилжүүлэх ажил /автозам №5-1/ ГЦ.1-ГЦ.13 /автозам №5-1/ 0.386км автозамын гадна гэрэлтүүлэг ГГ.1-ГГ.15 шифр БЭ-2016/047</li> <li>- зураг төслийн "Бумбын эрин" ХХК Инженер: Л.Алтанчимэг, Д.Ганбат</li> </ul>
<b>3. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7-р зүйлээс/</b>		
4	7.5.1. барилга байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зураг, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	"Гео зураглал" ХХК-д хийгдсэн автозамын зургийн дагуу
5	7.5.2. барилга, байгууламжийн архитектур төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	БНЗӨБЦТС ТӨХК-ийн Хэнтийн салбарын 2016 оны 08-р сарын 6-ны өдрийн 16-ны өдрийн 28/16 тоот техникийн нөхцөл
6	7.5.3. барилга байгууламжийн байршил, хот төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон байршил, талбайн инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаархи дүгнэлт;	БНЗӨБЦТС ТӨХК-ийн Хэнтийн салбарын ерөнхий инженертэй зөвшилцсөн
7	7.5.4. зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байдал;	
8	7.5.5. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны	

	эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	
9	7.5.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	хамаарахгүй
10	7.5.7. хөрсний бохирдлоос хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үйлдвэрийн бохирдсон усыг цэвэрлэж ашиглах боломж, гадагш хаяж байгаа бохирдсон агаар, ус норматив үзүүлэлтийг хангаж буй эсэх;	хамаарахгүй
11	7.5.8. инженерийн шугам сүлжээний уртын дагуухь төлөвлөлтийн оновчтой шийдэл;	оновчтой
12	7.5.9. барилга байгууламжийн гаднахь ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	-
13	7.5.10. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	-
14	7.6. Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	-
Дүгнэлт бичсэн: Эксперт №61-02 З.Бүжинлхам /овог, нэр/ ..... /гарын үсэг/ 2016 оны 09 сарын 16-ны өдөр		

**Зураг төслийн баримт бичгийн  
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ**  
ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН  
НЭР..... цахилгаан.....

2016..оны...09.....сарын 16..өдөр

д/д	Экспертийн санал, шлэрсэн алдаа зөрчил	Биелэлт
1	Зураг төслийг Цахилгаан байгууламжийн дүрэм БД43-101-03, Барилга байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар БД43-103-08, MNS-3757-22:2007 дагуу төлөвлөсөн	
Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № ..... /овог, нэр/ 2016 он 9 сар 16 өдөр		
Биелэлтийн тайлбар бичсэн ..... /овог, нэр/ ..... он .... сар ..... өдөр		

Эксперт дүгнэлтийг компьютерээр 2 хувь бичиж, гарын үсэг, тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2016 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 4/312

Хэрлэн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "в", 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 96 дугаар тогтоолын дагуу Хэнтий аймгийн Чингис хотод гудамж төсөл хэрэгжих 4 замын байгууламжийн байршил хэмжээг дараах байдлаар тогтоон аймгийн Засаг даргын тамгын газарт 5 жилийн хугацаатай газар эзэмших эрх олгосугай. Үүнд:

1.1 Хэрлэн сумын 4 дүгээр баг Их тойруугийн замаас хойш Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх албаны хашааны зүүн хойд уулзвар хүртэлх 0.637 км авто замд зориулан 1.27 га

1.2 Хэрлэн сумын 3 дугаар баг Хөдөлмөрийн хэлтсийн баруун хойд талын уулзвараас Давхар дэлгүүрийн баруун хойд талд хүртэл, Соёолж худалдааны төвийн зүүн хойд талаас Мөнхшувуут ХХК-ий зүүн урд талын уулзвар хүртэл 0.422 км авто замд зориулан 0.63 га


1.3 Хэрлэн сумын 4 дүгээр баг Цахилгаан түгээх сүлжээ салбарын баруун талын уулзвараас Цэцэн хан худалдааны төвийн зүүн талын уулзвар хүртэл 0.5 км авто замд зориулан 0.75 га

1.4 Хэрлэн сумын 5 дугаар баг Сариг хорооллын баруун урд уулзвараас хойшоо Шинэ Өндөрхаан чиглэлийн 1.365 км авто замд зориулан 2.73 га

1.5 Хэрлэн сумын 5 дугаар баг Соёлын төвийн хойд талын уулзвараас хойш Сариг болон Дулаан хорооллын дундуур хойш үргэлжлэх 0.993 км авто замд зориулан 1.49 га

Хоёр. Дээрхи барилга байгууламжийн төлөвлөлтийн шийдлийг хянан батлах, кадастрын бүртгэлд бүртгэх, барилга угсралтын ажилд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т, Авто тээврийн төв /Н.Санжаадорж/рр-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.ОЮУНБААТАР

БАТЛАВ:

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Ж.ОЮУНБААТАР



ХЭНТИЙ АЙМАГ, ЧИНГИС ХОТЫН ТӨВИЙН ШИНЭЭР БАРИГДАХ АВТО  
ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ  
БОЛОВСРУУЛАХ ЗУРГИЙН ДААЛГАВАР

№ 05/2016

1	Зураг төсөл зохиох үндэслэл	Гудамж төслийн барих, шилжүүлэх концессийн гэрээнд тусгагдсан авто замын барилгын хөгжлийн чиг хандлага баримт бичиг
2	Замын техникийн зэрэг	Нутаг дэвсгэрийн зам, Орон сууцны хорооллын гудамж зам
3	Байршил	Хэнтий аймгийн төв
4	Замын хучилтын хийц	Боловсронгуй төрлийн хучилттай. Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ
5	Газрын бартаалаг, төвөгшил	Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах
6	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай 2016 он
7	Захиалагч байгууллага	Хэнтий аймгийн Засаг Даргын Тамгын газар
8	Зургийн төслийн байгууллага	Гэрээгээр
9	Барилгын гүйцэтгэгч байгууллага	Гэрээгээр
10	Барих хугацаа	2016 он, 2017 он
11	Хөрөнгийн эх үүсвэр	Шаньдун Гуован Чимин компани

## 12. Онцгой нөхцөл :

- Авто замын зургийг Монгол улсад мөрдөж буй “Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ” БД81-104-02, “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04, “Хотын зам төсөллөх” БД32-01-04, “Авто зам төсөллөх” БНБД 32.01.07, “Авто замын гүүр ба хоолой БНБД 32-02-03, Монгол улсын стантандарт Автозамын салбарт мөрдөх стандартын, замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2007, MNS 4597:2014, MNS 4759:2014, MNS 4980:2014, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замын төлөвлөх заавар MNS 6056:2009 болон бусад холбогдох норм дүрм стандартуудыг үндэслэх.
- “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил” БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах.
- Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглалын ажлын иж бүрэн тайланг батлуулан хүлээлгэн өгөх, зам барилгын ажлын үед геометр хэмжээг хангах, хэмжилтийн төсөлд даалгавар боловсруулах. Авто зам, уулзварын өргөтгөл шинэчлэлтийн ажлын зурвас газарт орсон түр реперийг байгуулж, барилгын ажлын бэлтгэл хангах. Геодезийн хяналтын инженерээр хянуулж баталгаажуулах.
- Авто замын дагуух үзэгдэх орчинг тооцож, саад болж буй объектуудыг буулгахаар зураг төсөвт тусгах.
- Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрт хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох.
- Шороон ордын /карьер/ судалгааг дүүргэгч бүрээр тодорхойлж, тооцоолох.
- Инженерийн шугам сүлжээний байгууллагуудын техникийн нөхцлийг тусгах, ажлын зураг боловсруулах, холбогдох байгууллагуудтай зөвшилцөх, ажлын зургийг батлуулах.
- Авто замын үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, автомашин, явган хүний гарц, явган хүний замыг тусгаарлах зориулалтын хайс хашлага төлөвлөх, гадаргуугийн усыг зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг

иж бүрнээр төсөллөх. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх.

- Авто замын зорчих хэсгийн төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах, захиалагчийн саналыг тусгах.
- Одоо байгаа замд ашиглалтын байдлын судалгаа хийж түүнд үндэслэн засварын ажлын төрөл тоо хэмжээг тодорхойлох.
- Огтлолцож буй авто замын уулзварын бодит хөдөлгөөний эрчим ба нэвтрүүлэх чадварыг тодорхойлж, хэтийн хөдөлгөөний эрчим болон хот төлөвлөлтийг үндэслэн түүнийг шинэчлэн өргөтгөх.
- Авто зам, уулзварын хөдөлгөөн зохион байгуулалтыг оновчтой төлөвлөх. Хөдөлгөөний эрчмийн тооллогыг дараах байдлаар явуулах, дүн шинжилгээ хийх Үүнд:
  - Чиглэл тус бүрээр өнгөрч буй суудлын авто машин, мотоцикль, ачааны автомашин, автобусны тоог цаг цагийн нарийвчлалтай тогтоох,
  - Чиглэл бүрээр өнгөрч буй тээврийн хэрэгслийн дундаж хурдыг тооцоолох, (Дундаж хурд гэдэгт өмнөх уулзвараас /авто зам/ өргөтгөн шинэчилж буй уулзвар /авто зам/ хүртэл зорчих дундаж хурд)
  - Хөдөлгөөний эрчмийн тооллогыг ажлын 3 хоногийн туршид явуулах,
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг /гэрлэн дохио/ иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах ба зураг төслийг боловсруулахдаа холбогдох байгууллагуудтай зөвшилцсөн байх. Хэвтээ тэмдэглэгээний ажлын зургийг өмнөх ашиглаж байсан үндсэн замын тэмдэглэгээтэй уялдуулах, мөн эгнээ байр шилжсэн тухай мэдээллийн / өндрийн/ тэмдэгийн байршлыг зааж төлөвлөх.
- Авто зам болон уулзварын гэрэлтүүлгүүдийг уулзварт төлөвлөгдөх арал, замын зорчих хэсэг болон явган хүний замыг бүхэлд нь гэрэлтүүлэх орчин үеийн техникийн шаардлагад нийцсэн гэрэлтүүлгийн байгууламжийг сонгох, өмнө нь ашиглагдаж байсан гэрэлтүүлэгч, шон, тэжээлийн холболтуудыг шинэчлэх, энэ талаар мэргэжлийн болон ашиглагч байгууллагын саналыг тусган төлөвлөх.
- Авто машины зогсоолын хөдөлгөөн зохион байгуулалтыг цогцоор нь шийдэх, орц гарцыг замын нэвтрүүлэх чадварт нөлөөлөхгүйгээр төсөллөх, тэмдэг тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах.

- Авто зам, уулзвар болон авто зогсоолын ус зайлуулах байгууламжийг цогц байдлаар шийдвэрлэх. Замын дагуух гадаргуун ус зайлуулах байгууламжийг орчноор нь тооцож шийдвэрлэх.
- Ногоон байгууламж, мод, ногоон хайс, сандал, хогийн сав, явган зам талбайг авто зам болон орчны барилгуудтай уялдуулан шийдвэрлэх.
- Түүх, соёлын үнэт өв дурсгал замын трасст орсон тохиолдолд холбогдох байгууллагуудтай зөвшилцөн хамгаалах болон нүүлгэн шилжүүлэх ажлыг эцэслэн шийдвэрлэсэн байх.
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:
 

➤ Ерөнхий төлөвлөгөө	1:1000-1:5000
➤ Дэвсгэр зураг	1:500
➤ Дагуу огтлол хэвтээ	1:2000
босоо	1:200
➤ Хөндлөн огтлол	1:200
➤ Уулзвар, огтлолцол	1:500
➤ Хөдөлгөөн зохион байгуулалт	
авто зам	1:500
уулзвар	1:200
➤ Гудамжны эзэлхүүний зураг	1:50
➤ Бүтээц	1:20
- Зургийн тайлбар бичигт төсөллөж буй авто зам, уулзвар, авто зогсоол болон бусад байгууламжийн товч тодорхойлолт, ашиглагдаж буй авто зам, гүүрийн техник ашиглалтын нөхцөл, авто зам баригдах газрын байгаль цаг уурын статистик мэдээ, трассын дагууд инженер геологийн эрэл хайгуулын судалгааны дүгнэлтийн тайлан /зам барилгын материалын карьеруудын байршлын хамт/, геодезийн хэмжилтийн иж бүрэн тайлан, төслийн шийдэлд онцгой нөлөө үзүүлэх аливаа байгаль цаг уурын хүчин зүйлсийн тухай мэдээ, замын трассыг техник эдийн засгийн үр ашиг өндөртэйгээр байгуулсан төсөллөлтийн үндсэн шийдлүүд, төслийн шийдлийн хувилбарууд, төслийн тухайн шийдэлд бий болох техник эдийн засгийн үр ашгийн тодорхойлолт, хэрэглэсэн шинэ техник технологи болон хөрөнгө оруулалтын үр ашгийн тооцоо, зам барилгын ажлын тоо хэмжээ, хэрэглэгдэх машин, механизмын жагсаалт, зам барилгын ажилд тавигдах техникийн шаардлага орсон байна.



- Авто зам, уулзварын ажлын нэгдсэн төсөвт өртөгт инженерийн байгууламжтай холбоотой объектуудын нүүлгэх, шилжүүлэх, буулгах зардлуудыг инженерийн байгууламжийн ажлын зураг боловсруулах туслан гүйцэтгэгч нарт анхааруулж тусгуулах. Мөн авто замын барилгын ажлын төсөвт түр барилга ба аж ахуйн бэлтгэл ажил, объект ашиглалтад оруулах, хог хаягдал цэвэрлэх, зурваст орсон геодезийн хатуу цэгийг шилжүүлж шинээр байгуулах, лабораторийн туршилт шинжилгээний ажлуудтай холбоотой зардлуудыг заавал тусгах.
- Авто зам, замын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, нэгдсэн төсөвт өртгийн тооцоо болон бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 3ш, тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө.

**Хянасан:**

Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

Ж.ДЭЛГЭРМАА

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Д.БАЯРХҮҮ

**Зөвшөөрсөн:**

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, Аймгийн ерөнхий архитектор

Д.БАТТУЛГА

**Боловсруулсан:**

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Ш.АРИУНБОЛОР



2016 оны 07 дугаар сарын 02-ны өдөр



**ХЭНТИЙ АЙМАГ  
НИЙТИЙН АЖ АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
“ХЭНТИЙ УС” ХХК**

23123 Чингис хот Хэрлэн сум  
Утас: 70-56-22-74, Факс: 70-56-22-74  
Вэб: www.Khentii-us.mn, И-мэйл: Khentii-us@yahoo.com

2016.07.07 № 328  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Техникийн нөхцөл гаргах тухай**

2016 оны 07 сарын 01-ний өдөр бид танай компаний инженерүүдтэй хамтарч Хэнтий аймгийн Чингис хотын төвд баригдах 4 км асфальт бетон хучилттай авто замын трассын дагуу цэвэр, бохир ус, дулааны шугам болон худгуудын хэмжилтийг хийсэн. Үүнд замын трассын дагуу цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээ, худгууд байгаа тул трассыг хөндлөн огтолж буй шугамуудыг хүчитгэх, трассын дагуу шугамуудын дээрх замыг задлан буулгаж шугам сүлжээнд засвар үйлчилгээ хийх, замыг сэргээн засварлах боломжтойгоор шийдэх шаардлагатай байна.

Хамтран ажилласанд баярлалаа.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  Д.ДАРХАНБАЯР



Мэдээлэл Холбооны сүлжээ ХХК-ийн

Хэнтий аймгийн газрын дарга

 /Ж.Равжих/

Техникийн нөхцөл: № 16/14

Огноо: 2016.07.27

Захиалагч байгууллага: ГЕО ЗУРАГЛАЛ ХХК

Харилцах утас: 313693,312897

1. Байршил: Өндөрхаан сумын нутагт
2. Байршил: "Гудамж" төсөл
3. Техникийн үндсэн нөхцөл

1. 1 дугаар зам /Хөдөлмөрийн хэлтсийн баруун уулвараас урагшаа Төв дэлгүүрийн баруун замын уулзвар хүртэл/

ССС-01 шүүгээний Ех 18-2, ЕХ-18 2-1 хоорондох худагын сувагчлал дайран гарах тул нэмэлт 1ш 100dm яндан тавих. СССР-01 шүүгээний ЕХ-17, ЕХ-18 худагын хуучин, шинэ сувагчлалд хамгаалалт хийнэ.

Материал: - 100dm яндан

2. 2 дугаар зам /Эрчим хүчиний баруун уулзвараас баруун чиглэлд Хэрлэн тооцооны төв, А24 байрны баруун талаар урагшаа төв зам хүртэл

ССС-05 шүүгээний Ех26-2, Ех26-3 хоорондох, ЕХ25-2, ЕХ25-3 хоорондох. СССР-01 шүүгээний Ех 20, Ех21 -ын хоорондох сувагчлал дээгүүр гарах тул хүчитгэсэн хамгаалалт хийнэ. Мөн шинэ сувагчлал дээгүүр дайран гарах тул хүчитгэсэн хамгаалалт хийнэ. Хэрлэн ХААН тооцооны төвийн Физик ТГБ-10\*05 газрын кабель замын трассд орж байгаа тул шилжүүлэх зам доогуу 50dm сувагчлалтай хийнэ. Явган хүний замд орж байгаа ЕХ 25-3, ЕХ 25-3-1, ЕХ 22 худагуудыг өндөрлөнө.

Материал: - ТПП-10\*05 кабель  
- 50dm яндан  
- ТПП-10 хосын муфть

3. 3 дугаар зам /Хорихийн зүүн хойд уулзвараас урагшаа/

ССС-09 шүүгээний салбар газрын ТПП-200 хосын кабель, Цагдаагийн камерын шилэн кабель хамгаалалт хийх. Р15-Р10 агаарын багана ТПП-50 хосын кабель шилжүүлнэ. Зам доогуур 2 газраар сувагчлал тавина.

- Материал:**
- Багананы хөлний боолт
  - ТПП-50 хосын кабель
  - ТПП-50 хосын муфть
  - 100dm яндан

**4. 4 дугаар зам /Нефт баазын зүүн талаар хойшоо Шинэ Өндөрхаан хорооллын урдуур /**

ССС-07-ний салбар газрын ТПП-200 хосын Физик кабель, СССР-06 гол ТПП-200 хосын кабелийн траас дээгүүр гарч байгаа тул хамгаалалт хийнэ. Мобикомын газрын шилэн кабель 2 газрын зам доогуур орж байгаа тул хүчтгэсэн хамгаалал хийнэ. СССР-07 шүүгээний Р14, Р11 баганыг ТПП-50 хосын газрын кабельтай хамт шилжүүлэх. Шинэ зам доогуур 2 газар сувагчлал тавина.

- Материал:**
- Физик кабель 50 хос
  - 50 хосын муфт
  - 100dm яндан
  - хөлийн боолт 06мм ган утас

**5. 5 дугаар зам /САА-н соёлын төвийн хойд уулзвараас хойшоо/**

ССС-07 шүүгээний агаарын ТПП-50,30,10 хосын кабель шилжүүлэх. Цагдаагийн камерын шилэн кабель/газар, агаарынх/шинээр хийх замын трассын дагуу орсон. 2 газар зам доогуур гаргалаа хийнэ. 100dm сувагчлал тавина.

- Материал:**
- 100dm яндан
  - ТПП-50,10,30 хосын кабель.
  - ТПП-50,30,10 хосын муфть
  - Багананы хөлний боолт

Хянасан:

Ерөнхий инженер ..... / О.Од-Эрдэнэ /

Боловсруулсан:

Кабель шугамын техникч ..... / С.Давааням /

БАТЛАВ. БЗӨБЦТС ТӨХК-ИЙН ХЭНТИЙ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ

САЛБАРЫН ДАРГА

Ч.ОЮУНБОЛД

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ



1. 2016 оны 08-р сарын 06-ны өдөр

№ 28/16

Чингис хот

2. Техникийн нөхцөл  
хүссэн иргэн, хуулийн этгээд  
болон байгууллага:

"ГЕО ЗУРАГЛАЛ" ХХК

3. Хэрэглэгчийн хаяг:

Хэнтий аймаг Чингис хот

4. Хэрэглэгчийн байршил,  
зэрэглэл:

Хэнтий аймаг 3,4,5 баг

5. Ажил үйлчилгээний  
зориулалт:

Чингис хотын төвд баригдах 4 км замын трассанд орсон 6/0,4 кВ дэд станц, 6кВ, 0,4кВ, 0,22 кв ЦДАШ кабель шугам шилжүүлэх, өндөрлөх, сувагчлалтай болгох.

6. Техникийн нөхцөл  
олгох үндэслэл:

"ГЕО ЗУРАГЛАЛ" ХХК 2016 оны 07-р сарын 01-ны өдрийн өргөдөл

7. Суурилагдсан чадал:

0

8. Холбогдох цэг:

7.1 Хэнтий аймаг 6/0.4кВ КТП-125, АТП-108, ТП-6 дэд станцыг зөөх. 110/35/6 кВ дэд станцын ЯЧ№7,5,10 Нисэх, Булаг, Хангал, 6 кВ кабель шугамын трасс өөрчилнө. Хангал 6 кВ ЦДАШ-ын Тулгуур №1,20,21,22,23, Сариг 6 кВ ЦДАШ-ын тулгуур №2,3 Дизель 6 кВ ЦДАШ-ын тулгуур №2,82,83,84,85,86 трасс өөрчилнө.

7.2. Хангал 6 кВ тулгуур №51,52 болон Сариг 6 кВ 16, АТП-34 портал өндөрлөх.

7.3 0,4 кВ ЦДАШ-ын болон кабель шугам трассыг дараах байдлаар өөрчилнө. ТП-6 дэд станцын Бөртөг, Загалмай, Ганга, Бүрд гаргалгааны 0,4 кВ ЦДАШ-ыг буулгаж 0,4 кВ кабель шугамын тунель шинээр хийж хэрэглэгч болгоныг бэлтгэл кабель шугамаар хангана.

7.4 ТП-6 дэд станцад 0,4 кВ 2 ширхэг ячайк шинээр суурилуулан угсарч, Бөртөг, Загалмай, Ганга, Бүрд

7.5 ТП-1 0,4 кВ Эрдэс,Төв зуух гаргалгааны тулгууруудыг буулгаж төмөр бетон тулгуураар сольж,сип утас татна.

7.6 АТП-34 Дулаан 0,4 кВ гаргалгааны тулгуурыг өндөрлөж,0,4 кВ шугамын дамжуулагчийг АС-50 утасаар солих.

7.7 10.1 Ямарч хүчдлийн кабель шугам, ЦДАШ-ыг трассыг өөрчилөх,өндөрлөх арга хэмжээг хангагч байгууллагтай хамтран зөвшилцөж гүйцэтгэнэ.

## 9. Тоолуур хэмжих хэрэгсэл:

8.1 Монгол Улсын Стандартчилал хэмжилзүйн үндэсний төвөөс загварын туршилтанд орж, ашиглахыг зөвшөөрч баталгаажуулсан 100 А-ийн электрон тоолуур тавьж ЦЭХ-ний тооцоо хийнэ.

## 10. Тусгай заалтууд:

10.1 Шинээр баригдах объектын цахилгаан хангамжийн ажлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн техникийн нөхцөл олгогчоор хянуулна.

10.2 Шинээр угсрах кабель шугамын трассын зураг схемийг Хэнтий ЦТСС-ийн инженер техникийн ажилчидтай хамтран гаргана.

10.3 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн щитъ тоноглолыг "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн 1.6.36-д заагдсаны дагуу 4 Ом-оос ихгүй байхаар газардуулсан байна.

10.4 Хэрэглэгчийн баригдах объект нь бусдын эзэмшлийн газар нутаг, инженерийн байгууламжийг дайрч байвал холбогдох эзэмшигчээс зөвшөөрөл авна. Мөн объектын хамгаалалтын зурвас, газрын зөвшөөрлийн талаар холбогдох албан газраас нь зөвшөөрөл авна.

10.5 Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдлийн түвшингийн  $\pm 5\%$ -ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, экологид сөрөг нөлөөлөлгүй орчин үеийн шинэ найдвартай тоног төхөөрөмж суурилуулна.

10.6 Цахилгааны оруулга, гаргалгын кабель шугам, барилгын дотор монтаж, угсралтын ажлыг "Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл"-тэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

10.7 Шинээр баригдах шугам тоноглолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэж, шаардлагатай туршилт хэмжилтийг

Хэнтий ЦТСС-аар хийлгэж, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.

**11. Дор дурьдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:**

**11.1** Техникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсний дараа “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 4.22, 4.23-р заалт БЗӨБЦТС ТӨХК-ийн “Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох объектыг ашиглалтанд хүлээн авах журам”-ийн дагуу холбогдоно.

**11.2** Цахилгаан тоноглол болон агаарын шугам, кабель шугмын ашиглалт үйлчилгээний талаар Шуурхай үйлчилгээний хэсэгтэй, цахилгаан эрчим хүчний тооцооны талаар Хангах хэсэгтэй тус тус гэрээ байгуулж ажиллана.

**11.3** Хэрэглэгч нь Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 30.1.2 30.1.3 30.1.4 30.1.7 30.1.8-р заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

**11.4** Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, үйлдвэрлэлийн бүс, барилга байгууламж барих, өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрсөнөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

**11.5** Хэрэглэгч нь “Эрчим хүчний тухай” хуулийн 30.1.3 дахь заалтын дагуу өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчдийг тэжээх үүрэгтэй.

**11.6** Цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь Монгол Улсын Эрчим Хүчний тухай хууль болон цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

**11.7** Энэхүү техникийн нөхцлийн дагуу барилга угсралтын ажлыг нэг жилийн хугацаанд хийж гүйцэтгэн сүлжээнд холбогдох бөгөөд энэ хугацаанд ажлыг хийгээгүй тохиолдолд дахин шинээр техникийн нөхцөл авна.

Техникийн нөхцөл олгосон:

ТҮАХ Ерөнхий инженер

Х.Ганчулуун